


### Эдийн засгийн огцом өсөлт бий боллоо

2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ оны үнээр 10,830 тэрбум төгрөг болж, эдийн засгийн өсөлт 17.3%-д хүрэв.


Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын өсөлт буурч байхад энэ нь олон улсын хэмжээнд хамгийн өндөр өсөлт байлаа. Уул уурхайн салбарт түшиглэсэн өсөлт, дэлхийн зах зээл дэх зэсийн өндөр үнэ, нүүрс болон төмрийн хүдрийн экспорт эрс нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дагуулж байна.



### Улсын төсөв ашигтай гарав

Төсвийн орлого энэ сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.7% нэмэгдэж, харин зарлага 5.5% буурлаа.

Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 28% буурсан ч гадаад худалдааны татварын орлого 4 дахин өсч, татварын нийт орлого 46% нэмэгдсэн нь улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 66 тэрбум төгрөгийн ашигтай гарахад нөлөөлжээ.




### Гадаад худалдааны алдагдал өссөөр

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын өсөлт экспортын өсөлтөөс 2.8 дахин хурдтай байж, гадаад худалдааны алдагдал 82% өслөө.

Экспорт 15% өсөхөд нүүрсний экспорт 2 дахин, төмрийн хүдрийн экспорт 79%, зэсийн экспорт 10% тус тус нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн бол импорт 42% өсөхөд автобензиний импорт 3 дахин, дизель түлшний импорт 2 дахин нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Харин хүнд тоног төхөөрөмжийн импорт дунджаар 35% буурчээ.



### Төгрөгийн ханш суларсан хэвээр

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх сараас 1.5%, оны эхнээс 1.5%, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11% сулрав. Гадаад валютын нийт албан нөөц өнгөрсөн сараас 3.2% буурч, 2.4 тэрбум ам.долларт хүрчээ.


МБ арилжааны банкуудын саналын дагуу гадаад валютын нийт 7 дуудлага худалдаанд оролцож, 102.95 сая ам.доллар худалдсан байна.



### Инфляцын түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага байна

Инфляцын түвшин өмнөх сартай харьцуулахад 2.8% өссөн бөгөөд энэ өсөлтөд тээврийн үнийн дундаж түвшин 5.3%, хүнсний бараа, ундаа, усны үнийн дундаж түвшин 4.9% өссөн нь голлон нөлөөлжээ.

Жилийн инфляцын түвшин 10.2% байна.




Эх сурвалж: УСХ, МБ

### Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас буурчээ

M2 мөнгө буюу мөнгөний нийлүүлэлт 6.148 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 28% өсч, харин өмнөх сараас 4% буурсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас буурахад төгрөгийн болон гадаад валютын харилцах буурсан нь нөлөөлөв.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний нийт мөнгөнд эзлэх хувь буурах хандлагатай байна.



### Төгрөгийн хадгаламжийн өсөлтийн хурд саарч байна

Нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.7% өссөн ч өмнөх сараас 0.1% буурсан байна.


Өмнөх оны мөн үетэй харьцуулсан төгрөгийн хадгаламжийн өсөлт өнгөрсөн онд сард дунджаар 70% байсан бол энэ сард 27.8% болж буурсан байна.

Төгрөгийн болон валютын хадгаламжийн жин 74:26 хувийн харьцаатай байна.



### Чанаргүй зээлийн хэмжээ буурч байна

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64% өсөж, чанаргүй зээлийн хэмжээ 9.6% буурлаа. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.8% болж, өмнөх оны мөн үеэс 1.8 дахин буурчээ.



Эх сурвалж: УСХ, МБ

### Сарын онцлох үйл явдал

- > Монгол банкны бодлогын хүү өөрчлөлтгүй 12.25% байна.
- > Бензин шатахуун, хүнсний зарим бараа, нийтийн тээврийн үнийн өөрчлөлтийг тогтворжуулах, Сангийн сайдаар ахлуулсан Зөвлөл байгуулагдлаа
- > Оюутнуудад 2011-2012 оны хичээлийн жилд сар бүр 70200 төгрөгийн тэтгэлэг олгох тухай журам батлагдлаа.
- > Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төслийг дэмжлээ

### Хураангуй

Төсвийн тэлэлт, гадаад худалдааны нийт бараа эргэлт нэмэгдэж буй нь эдийн засаг зогсонги бус байгааг харуулж байгаа ч гадаад худалдааны алдагдал нэмэгдэж байгаа, инфляцын түвшин өндөр байгаа зэрэг нь эдийн засгийн орчин эрүүл бус байгааг илтгэж байна.

Төсвийн тэнцэл энэ сард ашигтай гарсан нь гадаад худалдааны татварын орлогын өсөлтөөс хамаарчээ. Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн импорт нэмэгдэж байгаа ч импортын өсөлтийн хурд өндөр байгаагаас гадаад худалдааны алдагдал нэмэгдэж байна.

Монгол банк удаа дараа гадаад валютын дуудлага худалдаанд оролцсон нь дотоодын зах зээл дээрх ам.долларын эрэлт, нийлүүлэлт харьцангуй тэнцвэргүй байсныг харуулж байна. Импортын өндөр өсөлт нь гарах валютын урсгалыг нэмэгдүүлж, улмаар валютын эрэлт нэмэгдэж буй нь төгрөгийн ханш сулрахад нөлөөлжээ.

Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүд автобензин, дизелийн түлшний үнийг 1-р сарын 6-нд литр тутамд 235-260 төгрөгөөр нэмсэн нь иргэдийн хувьд хүнд тусч, инфляц өмнөх сараас 2.8% өсөхөд голлон нөлөөлжээ. Гэхдээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад инфляцын түвшин харьцангуй бага байна.

Банкны салбарын хувьд өнгөрсөн онтой харьцуулахад хадгаламжийн өсөлт, түүнийг дагасан зээлийн өсөлт бий болж байна. Гэхдээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өсөлтийн хурд нь саарч байгаа юм.